

# МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ.

## ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

“Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”- гийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгийн талаар

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

#### 1.1. Шалгалтын зорилго

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын 2018 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн 2016, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж тулгарч байгаа асуудлуудыг дүгнэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино.

#### 1.2. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Шалгалтын удирдамжийн хүрээнд тус сангийн 2016, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Г.Янжинсүрэн, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч С.Ариунаа нар 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн ажлын 10 хоногт багтаан шалгалтыг хийлээ.

#### 1.3. Шалгалтанд хамрагдсан асуудлууд

Шалгалтыг Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Засгийн газрын тусгай сангийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль болон Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, санхүүгийн холбогдох заавар журам, Сангийн сайдын 253 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал”-ыг удирдлага болгон хийв.

Санхүүгийн шалгалтыг явуулахдаа Засгийн газрын тогтоол, болон удирдах дээд байгууллагын даргын тушаал шийдвэр, холбогдох бусад эрхийн актуудыг үндэслэн сангийн үйл ажиллагааны орлогын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл үр дүн, мөнгөн хөрөнгийн зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэлд тусгасан байдал зэрэг санхүүгийн үйл ажиллагааг үндсэн баримт материалтай тулган шалгаж, холбогдох хүмүүстэй уулзан тодруулах замаар явуулсан болно.

“Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн үйл ажиллагааны төсвийн эрх захирагчийн нэгдүгээр гарын үсгийг 2016.01.01-нээс 2016.10.30 хүртэл дарга, хурандаа Ж.Наранбаатар, 2016.11.01-нээс 2017.12.25 хүртэл дарга, дэд хурандаа С.Батбямба, 2018.01.01-нээс дарга, хурандаа Д.Дамдинцэрэн хоёрдугаар гарын үсгийг 2016.01.01-нээс ахлах нягтлан бодогч, ахмад Э.Бат-Эрдэнэ нар тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

#### **1.4. Өмнөх шалгалтын талаар**

Тус сангийн 2016 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас ахлах аудитор Ж.Болормаа аудит хийж “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна. Уг дүгнэлтэд “Гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох сангийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлангууд болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна” гэжээ.

“Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн 2015, 2016 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийж “Зөрчилгүй” гэсэн дүгнэлт гаргасан байна. 2017 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хэсэгчилсэн аудит хийсэн боловч уг аудитын үр дүнгийн талаар ямар нэг дүгнэлт, зөвлөмж өгөөгүй байна.

#### **1.5. Орон тоо, удирдлага зохион байгуулалтын талаар.**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн “Бүтэц, орон тоо шинэчлэн батлах тухай” Б/1218 дугаар тушаал, мөн оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Б/1372 дугаар тушаалаар Шийдвэр гүйцэтгэх газар нь Мэргэжлийн удирдлагын хэлтэс, Мэдээлэл, лавлагаа, дүн шинжилгээний тасаг гэсэн зохион байгуулалттайгаар батлагджээ.

Батлагдсан орон тоогоор газрын дарга-1, хэлтсийн дарга-1, тасгийн дарга-1, бүс хариуцсан ахлах мэргэжилтэн-5, ахлах нягтлан бодогч-1, төлбөрийн данс хариуцсан ахлах нягтлан бодогч-1, мэргэжилтэн-8, аж ахуйн ажилтан-1, механикч-1, нярав-1, жижүүр-4, жолооч-3, тогооч-1, үйлчлэгч 1 буюу нийт 30 албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 2016 онд дэвшүүлсэн зорилт, Улсын ерөнхий гүйцэтгэгчийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээг үндэслэн бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах, үйл ажиллагааны төлөвлөгөөг биелүүлэх зорилт тавьж гүйцэтгэл үр дүнг тухай бүр тооцож иржээ.

#### **1.6. “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн үндсэн үйл ажиллагааны талаар**

Монгол улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-д зааснаар сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргадаг бөгөөд тус санд зориулан ажлын алба байгуулж санхүүжүүлэхийг хориглосны дагуу “Гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох сан” нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа Шийдвэр гүйцэтгэх албаны дэргэд үйл ажиллагаагаа явуулж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан” шинээр нэмэгдэн, хуулийн 21<sup>3</sup> дугаар зүйлийн 2-д Эрүүгийн хуулийн дараах зүйл, заалтад заасан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг уг сангаас олгохоор хуульчилжээ. Үүнд:

- ❖ Хүн алах /10.1 дүгээр зүйл/
- ❖ Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах /11.1 дүгээр зүйл/
  - ❖ Хүчиндэх /12.1 дүгээр зүйл/
  - ❖ Хүн барьцаалах /13.3 дугаар зүйл/
  - ❖ Хүнийг хууль бусаар хорих, хүчээр алга болгох /13.4 дүгээр зүйл/
  - ❖ Дээрэмдэх /17.2 дугаар зүйл/
  - ❖ Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах /19.3 дугаар зүйл/
  - ❖ Эрүү шүүлт тулгах /21.12 дугаар зүйл/
  - ❖ Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх /29.1 дүгээр зүйл/
  - ❖ Террор үйлдэх /29.8 дугаар зүйл/

Хуулийн хэрэгжилтийг хангах, нөхөн төлбөр олгох чиглэлээр Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 132 дугаар тогтоолоор “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам”-ыг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа ба эрх зүйн зохицуулалтын хүрээнд нөхөн төлбөрийг олгох сангийн удирдлага нь орон тооны бус “Сангийн зөвлөл” байхаар журамласан байна.

### **1.7. Сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны талаар**

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 132 дугаар тогтоолоор батлагдсан “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам”-ын

2.2. “Сангийн удирдлага нь орон тооны бус Сангийн зөвлөл /цаашид Зөвлөл” гэх/ байна.”

2.3.” Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна”.

2.4. “Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө” гэсний дагуу

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2012 оны А/63 дугаар тушаалаар “Орон тооны бус сангийн зөвлөл”-ийг байгуулж, улмаар мөн сайдын 2015 оны А/104, А/258 дугаар тушаалуудаар бүрэлдэхүүнийг шинэчлэн баталжээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн “Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” А/258 дугаар тушаалаар зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох ажлыг зохион байгуулах “Орон тооны бус сангийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнд дараах албан тушаалтнуудыг томилсон байна. Үүнд:

**Зөвлөлийн дарга:** Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн Захиргааны удирдлагын газрын дарга;

**Нарийн бичгийн дарга:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа Шийдвэр гүйцэтгэх албаны дарга;

**Гишүүд:**

Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн ;

Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүү, эдийн засгийн хөгжлийн хэлтсийн дарга;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Мэргэжлийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн г.м ;

*Дээрх журмын 2.5-д “Зөвлөлийн ажлын албаны үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар гүйцэтгэнэ”, 2.6-д “Сан нь тогтоосон журмаар үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ”. гэсний дагуу “Орон тооны бус сангийн зөвлөл” нь үйл ажиллагаандаа энэ журам болон “Засгийн газрын тусгай сангийн тухай” хууль, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулиудыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулж иржээ.*

Гэмт хэргийн улмаас хохирол учирч, гэм буруутай этгээдээр нөхөн төлбөр гаргуулахтай холбоотой, дээрх зохицуулалтын үйлчлэлд хамаарах шинээр гүйцэтгэх баримт бичиг, хохирогчийн хүсэлтийг үндэслэн “Орон тооны бус сангийн зөвлөл”-ийн хурлыг зохион байгуулдаг ба хурал зохион байгуулахаас өмнөх шатанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас нөхөн төлбөр хуваарилах гүйцэтгэх баримт бичиг, холбогдох материалыг сангийн зөвлөлийн даргад хүргүүлсний үндсэн дээр хурлын товыг тогтоон, хурал зохион байгуулж ажилладаг байна.

Нөхөн төлбөр хуваарилсан шийдвэрийн хэрэгжилтийг дараагийн товлон тогтоосон хуралд танилцуулдаг бөгөөд мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны арга хэмжээнд тусгагдаж, эрх зүйн

актын биелэлтийг улирал тутам гаргаж, дээд шатны байгууллагад тайлагнаж иржээ.

### **1.8. Эрх зүйн зохицуулалтын талаар**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>3</sup> дугаар зүйлийн 2-д заасны дагуу “Сангийн хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, Эрүүгийн хуульд /шинэчлэн найруулсан /заасан дор дурдсан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгоход зарцуулна” гэж заасан байна. Үүнд:

№	Эрүүгийн хуулийн зүйл, заалт	Эрүүгийн хуулийн зүйл, заалтын гарчиг
1.	81.1, 81.2	Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах
2	91.1, 91.2	Хүнийг санаатай алах
3	96.1, 96.2	Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах
4	108.3	Хүн хулгайлах
5	109.3	Хүнийг хууль бусаар хорих
6	112.3	Хүнийг барьцаалах
7	113.3	Хүн худалдаалах
8	126.2, 126.3	Хүчиндэх
9	147.3	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх
10	177.2	Зандалчлах
11	1781.2	Терроризм
12	251.2, 251.3	Эрүү шүүлт тулгах

Сангийн зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар 22 төлбөр авагчийн холбогдох материалыг хэлэлцүүлэн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/113 тоот тушаалын дагуу 21 иргэнд 80.3 сая төгрөг, 2016 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн А/103 дугаар тушаалаар 16 хохирогчид 51.3 сая төгрөг, 2016 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/23 тоот тушаалын дагуу 23 иргэнд 101.7 сая нийт 233.3 сая төгрөгийн нөхөн төлбөрийг төлбөр авагчид шилжүүлжээ.

“Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар 25.1 сая төгрөгийг зохих санд төвлөрүүлэх арга хэмжээг авч ажилласан байна.

### **1.9. Нөхөн төлбөрийн санхүүжилтийн талаар**

Эрх зүйн зохицуулалтын хүрээнд “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан” нь дараах эх үүсвэрээс бүрдэхээр заажээ Үүнд:

- ❖ шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө;
- ❖ замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчилд ногдуулсан захиргааны торгох шийтгэлийг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө;
- ❖ гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөр;

“Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн хөрөнгийн эх үүсвэрийг дээрх үйл ажиллагаанаас бүрдүүлэхээр заасан боловч зөвхөн торгох ялын 60 хувь болон шүүхийн шийдвэрт заасан гэм буруутай этгээдээс хохирол нөхөн төлсөн төлбөрийг төвлөрүүлсэн орлогоос бүрдэж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>3.9</sup>.”Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 21<sup>3.2</sup>-т заасан зориулалтаар өмнөх онд гарсан зардал болон төвлөрсөн орлогын гүйцэтгэлийг харгалзан тухайн жилд улсын төсвөөс санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг төлөвлөнө” гэж заасан байна.

Хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш 2012-2017 онд “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-д нийтдээ 1,772.9 сая төгрөг төвлөрүүлж 899.3 сая төгрөгийг 237 хохирогчид олгосон нь 50,7%-ийн гүйцэтгэлтэй байна.

### **1.10. Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгосон бүртгэл, эргэн төвлөрүүлэлтийн талаар:**

Монгол улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан эх үүсвэрээс бүрдүүлсэн хөрөнгөөр зарим төрлийн гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмт хэрэг учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан эмчилгээний хохирол, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод *нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа хамаардаг байна.*

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч болон түүний хууль ёсны төлөөлөгчид оршуулгын зардал, эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нөхөн төлбөрийг сангаас олгож байгаа ба нөхөн төлбөрийн хэмжээг хохирогч нас барсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй, хохирогчийн бие махбодид хүнд гэмтэл учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнээс ихгүй байхаар заажээ.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд төрөөс 804.1 сая төгрөгийг 216 хохирогчид олгосноос санд 96.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Нөхөн төлбөрт хамрагдсан гүйцэтгэх баримт бичгийг хянах явцад төлбөр төлөгч ....холбогдох ...төгрөгийн гүйцэтгэх баримт бичгийг үндэслэлгүйгээр хаасан байсныг улсын ерөнхий гүйцэтгэгчийн 2017 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 06 тоот Улсын байцаагчийн актаар хүчингүйд тооцож, холбогдох ажиллагааг сэргээсэн байна.

Шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай нь тогтоогдсон этгээдээс нөхөн төлбөрийг гаргуулахад оршин суух хаяг нь тодорхойгүй, ар гэрээс нь төлбөр гаргуулах боломжгүй, ялын дэглэмээс хамаарч олон жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэгдсэн, ажлын байраар хангах боломжгүй, эд хөрөнгөгүй, зэрэг байдлаас шалтгаалж үлдэгдэл төлбөрийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хангуулах ажил удааширсан байна.

## **ХОЁР. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧДОД НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ САНГИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтын дагуу Шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийн орлогод 2016 онд 159.4 сая төгрөг, 2017 онд 641.4 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

**Шүүхээс ногдуулсан торгох ялын 60 хувьтай тэнцэх мөнгөн дүнгийн үзүүлэлт дараах байдалтай байна.**

Д/д	Тайлант он	Орлогын нэр	Батлагдсан төвлө-лөгөө	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Биелэлт	
						илүү	дутуу
1	2016	Шүүхээс ногдуулсан торгох ялын 60 хувьтай тэнцэх мөнгөн дүн / <b>159.360.753</b> / Эргэн төвлөрүүлэлт / <b>25.099.414</b> / Сангийн яамны татан төвлөрүүлсэн / <b>740.785.944</b> /	600,000,000	233,298,816 НДЗ / 3.901.600 /	688,045,695		
		925,246,111.00					
2	2017	Шүүхээс ногдуулсан торгох ялын 60 хувьтай тэнцэх мөнгөн дүн / <b>641.383.496,40</b> / Эргэн төвлөрүүлэлт / <b>12.476.300</b> / Сангийн яамны татан төвлөрүүлсэн / <b>688.045.695</b> /	594,000,000	174,474,873	1,167,430,618.40		
		1,341,905,491.40					

“Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох сан”-гийн журмын дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/103 дугаар тушаалаар 51.3 сая төгрөг, 2016 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/113 дугаар тушаалаар 101.7 сая төгрөг, 2016 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн А/123 дугаар тушаалаар 80.3 сая төгрөгийг нөхөн олгосноор нийт 61 иргэний 237.2 сая төгрөгийн төлбөрийг зохих журмын дагуу барагдуулсан байна.

2016 оны үйл ажиллагааны нийт орлого зардлын гүйцэтгэлийг дэлгэрэнгүй байдлаар авч үзвэл Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтын дагуу Шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийн орлогод 159.4 сая төгрөг, Сангийн яам, татаас санхүүжилтийн авлагын 740.8 сая төгрөг, эргэн төвлөрүүлэлт 25.1 сая төгрөг, нэр данс зөрүүтэй гүйлгээний 5.8 сая төгрөг нийт 931.0 сая төгрөгийг төвлөрүүлж дараах байдлаар зарцуулсан байна. Үүнд:

Тайлант онд харилцах дансны үлдэгдэл 688.0 сая төгрөгийг Сангийн яаманд татан төвлөрүүлсэн бөгөөд татаас санхүүжилтийн авлагаар бүртгэж тайлагнажээ.

**Үйл ажиллагааны нийт орлого зардал /төгрөгөөр/**

**2016.12.31**

д/д	Үзүүлэлт	Мөнгөн дҮн	Тайлбар
<b>1</b>	<b>2016 оны 01-р сарын 01-ний мөнгөн хөрөнгийн үлдэгдэл</b>		
2	Шүүхээс ногдуулсан торгох ялын 60%	159,360,753.00	Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтын дагуу Шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийн орлого
	Эргэн төвлөрүүлэлт	25,099,414.00	Хууль журмын дагуу эргэн төвлөрүүлэлт
3	Авлага	740,785,944.00	Урьд оны үлдэгдлээс санхүүжих
4	Нэр данс зөрүүтэй гүйлгээ	5,760,000.00	НДЗөрүү гүйлгээ 2016.12.19-нд орсон.
<b>5</b>	<b>Нийт эх үүсвэрийн дүн</b>	<b>931,006,111.00</b>	
6	Бараа үйлчилгээний бусад зардал /210901/	233,298,816.00	"Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан"-г-аас Хууль зүйн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 08-ны А/103 тоот тушаалын дагуу 51,275,822 төгрөг, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2016 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/23 тоот тушаалын дагуу 101,672,966 төгрөг, 2016 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн А/113 тоот тушаалын дагуу 80,350,028 төгрөг, нийт 237.298.816 төлбөрийг 60 иргэнд олгосон.
7	Авлага	688,045,695.00	2016 оны 12-р сарын 29-ний өдрийн байдлаарх дансны үлдэгдлийг Сангийн яамнаас татан төвлөрүүлсэн зардал
8	Нэр данс зөрүүтэй гүйлгээ	5,760,000.00	Иргэн Сувданцэцэгийн нэр данс зөрсөнөөс үүссэн төлбөрийг шилжүүлсэн.
<b>9</b>	<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>931,006,111.00</b>	
<b>10</b>	<b>2016 оны 12-р сарын 31-ний мөнгөн хөрөнгийн үлдэгдэл</b>	-	

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар 18 хохирогчид 76.491.984 төгрөгийг хуваарилж, нөхөн төлбөрийг 2017 оны 5 дугаар сарын 03-ны өдөр төлбөр авагчид шилжүүлсэн байна. Мөн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/281 тоот тушаалаар 21 төлбөр авагчид 96.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгохоор шийдвэрлэсэн боловч тайлант хугацаанд олгогдоогүй байна.

**2017 оны үйл ажиллагааны нийт орлого ба зардлын гүйцэтгэл**

/ өссөн дүнгээр /

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
---	----------	------------	-----------



1	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>594,000,000.00</b>	<b>174,474,873.00</b>
4	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	594,000,000.00	174,474,873.00
7	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>594,000,000.00</b>	<b>1,341,905,491.40</b>
8	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	594,000,000.00	653,859,796.40
9	Хууль журмын дагуу эргэн төвлөрүүлэлт	594,000,000.00	12,476,300.00
10	Хууль журмын дагуу торгох ялын 60 хувь орлого	594,000,000.00	641,383,496.40
11	<b>САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>688,045,695.00</b>
12	Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого / 2016 оны жилийн эцэст Сангийн яаманд татуулсан мөнгө эргэж орсон /	0.00	688,045,695.00
13	<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>		<b>1,167,430,618.40</b>

Дээрх эх үүсвэрийн тооцоог нарийвчлан авч үзвэл үндсэн үйл ажиллагааны орлогоор төлөвлөрүүлсэн 1,341.9 сая төгрөгийн 688.0 сая төгрөг нь 2016 онд Сангийн яаманд татан төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн авлага, 641.4 сая төгрөг нь торгох ялын 60 хувь, 174.5 сая төгрөг нь Сайдын тушаалаар гарсан зарлага ба 12.5 сая төгрөг нь 2017 оны харилцах дансны үлдэгдлийг эргэн төвлөрүүлсэн орлого, 1,167.4 сая төгрөг нь тайлант онд зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

### **“Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гаас олгосон санхүүжилт болон зардлын гүйцэтгэлийн талаар**

“Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2012 оноос хойш өссөн дүнгээр 899.3 сая төгрөгийг олгосноос 2016 онд 233.3 сая төгрөгийг хохирогчид олгож, буцаан төвлөрүүлэлтээр 12.9 сая төгрөгийг төлүүлж барагдуулалт 5,5 хувьтай байна.

"Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам"-ын дагуу хохирогчид олгосон мөнгөн хөрөнгийн судалгаа

2018.05.23

№	ХЗСайдын тушаал		Сангаас олгосон		Дуусгавар болсон г/х	Санд төвлөрүүлсэн	Санд буцаан төвлөрүүлэх үлдэгдэл
	огноо	дугаар	төлбөр авагчийн тоо	хохирлын мөнгөн дүн			
1	11/2/2012	A/59	1	2,882,500		50,000	2,832,500
2	5/3/2013	A/96	7	18,748,370	1	2,384,978	16,363,392
3	9/4/2013	A/188	8	29,852,444	5	14,887,702	14,964,742
4	12/9/2013	A/253	9	19,708,903	1	2,322,912	17,385,991
5	3/13/2014	A/18	14	49,195,813	5	10,994,170	38,201,643
6	12/23/2014	A/240	47	196,005,476	11	36,278,354	159,727,122
7	3/24/2015	A/67	14	45,984,810	5	18,147,830	27,836,980
8	7/3/2015	A/146	21	68,220,655	8	16,618,320	51,602,335
9	11/24/2015	A/264	17	62,341,018		2,519,062	59,821,956
10	4/8/2016	A/103	16	51,275,822	4	9,716,350	41,559,472

11	8/29/2016	A/23	23	101,672,966	1	2,430,628	100,682,338
12	12/12/2016	A/113	21	80,350,028	5	12,952,436	67,397,592
13	18/04/2017	A/91	18	76,491,984		2,997,049	73,494,935
14	30/11/2017	A/281	21	96,583,889	2	9,479,251	87,104,638
Нийт дүн			237	899,314,678	48	141,779,042	757,535,636

Дээрх судалгааны дүнгээс харахад “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гаас Хууль зүй, дотоод хэргийн сайдын 14 удаагийн тушаалаар 237 төлбөр авагч /гэмт хэргийн хохирогч/-д 899.3 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар болон хоригдлын хөдөлмөрийн хөлсний суутгалаар төлбөр төлөгчөөс 141.8 сая төгрөгийг гаргуулан санд буцаан төвлөрүүлж, 757.5 сая төгрөгийн төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Нөхөн төлбөрт хамрагдсан төлбөрийг 194 төлбөр төлөгчөөс гаргуулж, санд буцаан төвлөрүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, үүнээс 18 төлбөр төлөгч хугацааны өмнө ялаас чөлөөлөгдсөн, 1 төлбөр төлөгч нас барсан, гадаадын харьяат 1 төлбөр төлөгчийг Монгол Улсаас албадан гаргасан, 174 төлбөр төлөгч хорих ял эдэлж байгаагаас ажлын байраар хангагдсан 88 хоригдол байна.

Үүнээс Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 132 дугаар тогтоолоор батлагдсан “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох журам”-ын дагуу 2016 онд “Эрүүгийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хохирогч болох 60 иргэнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар нийт 233.3 сая төгрөгийг сангийн данснаас олгожээ. Үүнд:

**“Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн  
зардлын гүйцэтгэл /2016.12.31/**

					/төгрөгөөр/
№	Тушаалын нэр	Огноо	Тушаалын дугаар	Хохирогчдын тоо	Мөнгөн дүн
1	Хууль зүйн сайдын тушаал	2016.04.08	A/103	16	51,275.822
2	Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал	2016.08.29	A/23	23	101,672.966
3	Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал	2016.12.12	A/113	21	80,350.028
Нийт дүн				60	<b>233,298.816</b>

Монгол улсын Тусгай сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу дээрх үйл ажиллагааны санхүүжилтэнд зориулж 2017 онд Шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилтэнд 173.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 174.5 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 1.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

**“Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн  
зардлын гүйцэтгэл /2016.12.31/**

/төгрөгөөр/

№	ТУШААЛЫН НЭР	ОГНОО	ТУШАА- ЛЫН ДУГААР	ОЛГОВОЛ ЗОХИХ ДҮН	ХОХИ- РОГЧДЫ Н ТОО	МӨНГӨН ДҮН
1	Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал	2017.04.18	A/91	76,491,984.00	18	76,491,984.00
2	Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал	2017.11.30	A/281	96,583,889.00	21	96,583,889.00
3	Хууль зүйн сайдын тушаал	2013.12.09	A/253	2013.12.09-ны тушаалаар нөхөн олгосон	1	1,399,000.00
ДҮН				173,075,873.00	40	174,474,873.00

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч болон түүний хууль ёсны төлөөлөгчид оршуулгын болон эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нөхөн төлбөрийг сангаас олгож байгаа ба нөхөн төлбөрийн хэмжээг хохирогч нас барсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй, хохирогчийн бие махбодид хүнд гэмтэл учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнээс ихгүй байхаар тогтоосон байна. Тухайлбал: 2017 онд шүүхийн шийдвэрийн дагуу нийт 39 иргэнд 220.5 сая төгрөгийг нөхөн олгохоор шийдвэрлэсэн боловч 173.1 сая төгрөгийг олгож журмын шаардлагын хэмжээнээс хэтэрсэн 47.4 сая төгрөгийг хасч тооцсон байна.

**Гэмт хэргийн хохирлын төлбөрт олгосон дээрх мөнгийг зардлын ангиллаар нь нарийвчлан авч үзвэл:**

Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйл, хүнийг санаатай алах гэмт хэргийн хохирогч болсон 52 хүний оршуулгын зардалд 205.4 сая төгрөг олгохоор тооцсоноос 22.6 сая төгрөгийг нөхөн олгож 182.8 сая төгрөгийг олгоогүй,

Мөн хуулийн 96 дугаар зүйл, Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэргийн нөхөн төлбөрт 5 хүний эмчилгээний зардалд 10.6 сая төгрөг олгохоор тооцсоноос 1.2 сая төгрөгийг нөхөн олгож 9.0 сая төгрөгийг төлөөгүй,

Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйл, хүчиндэх гэмт хэргийн нөхөн төлбөрт 6 хүний эмчилгээний зардалд 17.3 сая төгрөг олгохоор тооцсоноос огт төлөгдөөгүй зэргээр дээрх 3 төрлийн гэмт хэргийн хохирлын нөхөн төлбөрт нийт 63 хүнд 233.3 сая төгрөг олгохоор тооцсоноос 23.9 сая төгрөгийг нөхөн олгож 209.4 сая төгрөгийг олгоогүй байна.

Хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нөхөн төлбөрийг сангаас олгож байгаа ба нөхөн төлбөрийн хэмжээг хохирогч нас барсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөр олгох асуудлын хүрээнд холбогдох зардал гараагүй байна.

**ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДЛЫН ТАЛААР**

Эрх зүйн зохицуулалтын хүрээнд “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн эх үүсвэрийг шүүхээс ногдуулсан торгох ялын болон замын хөдөлгөөний дүрэм, хэв журмын зөрчилд ногдуулсан захиргааны торгох шийтгэлийг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 %-тай тэнцэх хэмжээний хөрөнгө, гэм буруутай этгээдээс хохирол нөхөн төлсөн төлбөрийг төвлөрүүлсэн орлогоос бүрдүүлж байхаар заасан боловч эдгээр орлогыг эх үүсвэрээр нь ангилж бүртгээгүй байна.

“Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн хөрөнгийн эх үүсвэрийг дээрх үйл ажиллагаанаас бүрдүүлэхээр заасан боловч зөвхөн торгох ялын 60 хувь болон шүүхийн шийдвэрт заасан гэм буруутай этгээдээс хохирол нөхөн төлсөн төлбөрийг төвлөрүүлсэн орлогоос бүрдэж байна.

Замын хөдөлгөөний дүрэм, хэв журмын зөрчилд ногдуулсан захиргааны торгох шийтгэлийг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 %-ийг тухайн санд төвлөрүүлж байсан боловч 2016 оноос хойш энэ санд тооцогдохоо больсон гэж байгаа боловч энэ талаар зохицуулалт хийсэн эрхийн акт, албан ёсны тушаал шийдвэр байхгүй байна. Гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөрийн орлогыг ангилж бүртгээгүйгээс энэ төрлийн орлогыг тодорхойлох боломжгүй байна.

“Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн төсвийг батлуулах, тодотголыг хийхдээ зардлын нарийвчилсан судалгаа гаргаж зайлшгүй шаардлагатай байгаа хөрөнгийн тооцоог гаргуулж төсөвлөсний үндсэн дээр хувьсах зардлын нормативыг үндэслэж тооцоогүй, шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тооцож төсөвт тусгаагүй зэргээр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>3</sup>.9. “Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 21<sup>3</sup>.2-т заасан зориулалтаар өмнөх онд гарсан зардал болон төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлийг харгалзан тухайн жилд улсын төсвөөс санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг төлөвлөнө” гэснийг зөрчсөн байна.

Гэтэл Хуульзүйн сайдын 2016 оны А/123 тоот тушаалаар нийт 23 хохирогчид 101.7 сая төгрөгийн нөхөн төлбөр олгохоор заасан боловч гүйцэтгэлээр 103.1 сая төгрөг олгож 1.4 сая төгрөгийн нөхөн төлбөрийг дутуу олгосон нь дээрх хуульд нийцэхгүй байна

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 132 тоот тогтоолоор батлагдсан Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журмын 1.1-д “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21.3.2-т заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулах”-аар заасан боловч дээрх ажлыг хуулийн дагуу зохион байгуулаагүй, мэдээллийн санд бүртгээгүй байна.

**“Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-ийн 21<sup>3</sup>.1.1-д “Шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө байна гэж заасны дагуу Торгох ялын төлбөрийн 60**

хувийг сангийн дансанд төвлөрүүлж байгаа боловч шүүхийн шийдвэрээр тогтоогдсон торгох ялын төлбөрийг бүрэн хэмжээгээр төлүүлж төсөвт төвлөрүүлж чадаж байгаа эсэхэд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-д Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хянах, 19 дүгээр зүйлийн 19.1-д Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмын зорилго нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 213.2-т заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгохтой холбогдсон харилцааг зохицуулахаар заасан боловч энэ талаарх мэдээллийг хэрэглэгч мэддэггүйгээс шалтгаалж зөвхөн өргөдөл гаргасан иргэнд олгох байдлаар тооцож иржээ.

Тухайлбал: 2016 онд Гэмт хэргийн нөхөн төлбөрт 600.0 сая төгрөг олгохоор төлөвлөж 237.2 сая төгрөг зарцуулж өмнөх оны шилжих үлдэгдлийг эргүүлэн татаж авсанаар 931.0 сая төгрөгийн эх үүсвэртэй, 2017 онд үндсэн үйл ажиллагааны орлогоор 1,341.9 сая сая төгрөг төлвлөрүүлж 174.5 сая төгрөг олгож 1,167.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Дээрх байдлаас дүгнэлт хийж үзэхэд нэг талаас төлөвлөгөө гүйцэтгэлийн үзүүлэлтүүд их хэмжээний зөрүүтэй байгаа нь төсвийн төлөвлөлттэй холбоотой боловч нөгөө талаас шүүхээс нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн гэмт хэргийн хохирогчдод төлбөрийг бүрэн олгодоггүйтэй холбоотой байна.

Мөн журмын 8.3-д “Хохирогчид нөхөн төлбөр олгох үйл ажиллагаатай холбоотой маргаан үүссэн тохиолдолд уг маргааныг хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд тухайн хохиролтой холбоотой нөхөн төлбөр олгох ажлыг түдгэлзүүлнэ.” гэж заасан боловч энэ талын судалгаа хийж үнэлэлт дүгнэлт гаргаагүй байна.

## **САНАЛ ДҮГНЭЛТ**

“Шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтанд тавих хяналт шалгалт, бүртгэл тооцоог сайжруулах замаар хохирогчдод олгох нөхөн төлбөрийн тооцоог бодитой хийж гүйцэтгэл үр дүнг сайжруулах талаар анхаарч ажиллаагүй байна.

“Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн орлогыг төлөвлөхдөө гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн судалгааг үнэн зөв гаргаж тухайн жилд шүүхийн шийдвэрээр олгохоор тооцсон хохирлыг ялын зүйл заалтаар ангилан хариуцагчийн болон төлбөр авагч хохирогчийн нэрээр ангилж бүртгэх ажлыг хуулийн дагуу зохион байгуулж хэрэгжүүлээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 132 дугаар тогтоолоор батлагдсан “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох олгох журам”-ын

6.1-д “Нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолд нэр нь заагдсан хохирогч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн банкин дахь харилцах /хадгаламжийн/ дансанд шилжүүлнэ.” гэж заасан боловч журам батлагдсанаас хойшхи хугацаанд нийт хэдэн хохирогчид холбогдох хичнээн төгрөгийн хохирлыг төлүүлэх талаар тооцоо хийж шүүхийн шийдвэр тус бүрээр тооцож гаргаагүй, энэ талаар мэдээллийн сан бүрдүүлээгүй байна.

Төсвийн төлөвлөлтийг үндэслэл, тооцоо, судалгаагүй хийснээс шалтгаалж тухайн жилд олгохоор тооцсон нөхөн төлбөрийн хэмжээ харьцангуй зөрүүтэй байгаа нь зардлыг үндэслэлгүйгээр нэмж батлах, жилийн эцэст зарцуулагдаагүй их хэмжээний үлдэгдэл гарахад нөлөөлсөн байна.

“Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн удирдлага, зөвлөл нь орон тооны бус байдгаас шалтгаалж энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох ажлыг зохион байгуулах, сангаас гаргаж байгаа тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, түүнд тавих хяналт сул байгаа нь сангийн журамд өөрчлөлт оруулах шаардлагатайг харуулж байна.

Шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай нь тогтоогдсон этгээдээс нөхөн төлбөрийг гаргуулахад оршин суух хаяг нь тодорхойгүй, ар гэрээс нь төлбөр гаргуулах боломжгүй, ялын дэглэмээс хамаарч олон жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэгдсэн, ажлын байраар хангах боломжгүй, эд хөрөнгөгүй зэрэг байдлаас шалтгаалж үлдэгдэл төлбөрийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хангуулах ажил удааширч байгаа асуудлыг судалж шийдвэрлэх шаардлагатай байна.

## **САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР**